

МУИС-ИЙН ПРОФЕССОРЫН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. МУИС-ийн судалгааны ажлын түвшинг дээшлүүлэх, судалгаанд суурилсан зохион байгуулалтын бүтэц бүрдүүлэх, залуу судлаачдыг зорилгоор профессорын баг бий болгон төлөвшүүлэх, багийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Нийгмийн чиглэлийн хувьд нэгдсэн зорилготой төлөвлөгөө, судлаач, суралцагчдаас бүрдсэн хамтлагийг профессорын баг /цаашид баг гэх/ гэнэ.
- 1.3. Баг нь сургалтын бодлогын хувьд бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба, тэнхимийн харьяанд ажиллана. Судалгааны ажлын чиглэл, багийн хүний нөөцийн хувьд бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн бодлогод уялдан ажиллах болно.

Хоёр. Профессорын багийн үндсэн чиг үүрэг

- 2.1. Сургалтын багц цагийн хэмжээнд чиглэлийн дагуу мэргэжлийн хичээлүүдийг заах, ахисан түвшний сургалтын чанарыг сайжруулах;
- 2.2. Сургалт судалгааны ажлын нэгдлийг хангах;
- 2.3. Судалгааны төсөл боловсруулан санхүүжилтын эх үүсвэр олох;
- 2.4. Судалгааны ажлын онолын түвшинг тасралтгүй дээшлүүлэх зарчим баримтлан ажиллах;
- 2.5. Судалгааг тэргүүлэх түвшинд явуулах;
- 2.6. Мэргэжлийн чиглэлийн дагуу эрдэм шинжилгээний хурал, семинар, симпозиум, түр сургалт зохион байгуулж мэргэжлээ сурталчлах;
- 2.7. Судалгааны ажлын үр дүнгийн нийгэм, эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлэх, хэрэгжүүлэхийн тулд санаачлага гаргах;
- 2.8. Суралцагчдыг судалгааны ажлын арга барилд сургах, авьяас чадварыг нээн хөгжүүлэх;
- 2.9. Судалгааны чиглэлийн дагуу сургууль, орон нутаг, улсын болон олон улсын түвшинд олон нийтийн үйлчилгээ үзүүлэх;
- 2.10. МУИС-ийн дүрэм журамд заагдсан бусад чиг үүрэг.

Гурав. Профессорын багийн бүтэц, зохион байгуулалт, профессорын сонгон шалгаруулалт, профессорын орон тоо, цагийн ноогдол

- 3.1. Бүрэлдэхүүн сургууль нь өөрийн судалгааны тэргүүлэх чиглэл болон улсын захиалгат судалгааны чиглэлийн хүрээнд тодорхойлогдсон судалгааны чиглэлүүдийн дагуу профессорын багийн зорилтот орон тоог суурь болон хэрэглээний чиглэлүүдээр эрдмийн зөвлөлөөрөө хэлэлцүүлэн тогтооно.
- 3.2. МУИС-ийн Эрдмийн зөвлөл нь бүрэлдэхүүн сургуулиас ирүүлсэн профессорын багийн тоо, судалгааны суурь санхүүжилтэнд тулгуурлан тухайн жилд шинээр ажиллуулах профессорын багийн боломжит орон тоог тогтооно. Тухайн судалгааны чиглэлээр зөвхөн нэг судалгааны баг

ажиллуулах бөгөөд МУИС-ийн Эрдмийн зөвлөл нь профессорын багийн ахлагчаар ажиллах шаардлагыг бүрэн биелүүлсэн профессорын тоонд нь уялдуулан бүрэлдэхүүн сургуульд тухайн жилд шинээр ажиллуулах профессорын багийн тоог тогтоож өгнө.

- 3.3. Нээлттэй сонгон шалгаруулалтаар багийн ахлагчийг шалгаруулна. Багийн ахлагчид нэр дэвшигчийн үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, олонхийн саналаар сонгон шалгаруулж МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 3.4. Багийн ахлагч нь МУИС-ийн профессор багшийн албан тушаалын шатлалын профессорын орон тоонд ажиллах ба бүрэлдэхүүн сургууль нь “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-ын дагуу багийн ахлагчийг нэгжийн профессорын боломжит орон тоонд оролцуулан тооцно.
- 3.5. Багийн ахлагч нь бүрэлдэхүүн сургуулийн захиралтай 3 жилийн хугацаагаар үр дүнгийн гэрээ байгуулах бөгөөд уг гэрээнд хэвлүүлэх бүтээл, хэрэгжүүлэх судалгааны төсөл, гэрээт ажил, хамгаалуулах магистрант, докторантын тоо болон зохион байгуулах олон улсын хурал, семинар зэргийг нарийн тусгана. Үр дүнгийн гэрээг суурь болон хэрэглээний чиглэлээр ялгавартай хийх ба суурь судалгаанд хэвлүүлэх бүтээлийн тоо, хэрэглээний судалгаанд эрдэм шинжилгээний үйл ажиллагаагаар сургуульд оруулах орлогын дүнг голлоно.
- 3.6. Багийн ахлагч нь эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар багийн үйл ажиллагааг тасралтгүй 6 сараас дээш хугацаагаар орхих тохиолдолд ахлагчийн үр дүнгийн гэрээг цуцлаж, ахлагчийг шинээр сонгох эсвэл багийг татан буулгах асуудлыг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 3.7. Багийн ахлагч нь жил бүр ажлын гүйцэтгэлээ бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлөөр дүгнүүлэх аа үр дүнгийн гэрээний хугацаа дуусахад биелэлтийг эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн нэгдсэн үнэлгээ гаргуулна. Энэ нь түүнийг улируулан томилуулах нөхцөл болно. МУИС болон үндсэн нэгжийн өмнө хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй багийн ахлагчийг өөрчлөх саналыг бүрэлдэхүүн сургуулийн захирал үндсэн нэгжийн эрдмийн зөвлөлд тавих ба эрдмийн зөвлөл хэлэлцэн дүгнэлт гаргана. Хангалтгүй үнэлэгдсэн нөхцөлд МУИС-ийн захирал үнэлгээг хүлээж авснаас хойш ажлын тав хоногт багтаан багийн ахлагчаас чөлөөлөх ба ахлагчийг шинээр сонгох эсвэл багийг татан буулгах асуудлыг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 3.8. Багийн ахлагч нь МУИС-д профессор, багш ажиллуулах журамд заагдсан хөдөлмөрийн насны хүрээнд ажил үүргээ гүйцэтгэх ба өндөр насны тэтгэвэрээ тогтоолгосон профессорын багийн ахлагч, гишүүдийг сургуулийн эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн багийн гишүүнээр ажиллуулж болно.
- 3.9. Багийн бүрэлдэхүүн багийн гишүүнээр ажиллуулж болно:
 - и дй о аһһй дуй ааааэй аааааа;
 - аааааааааа аааа /үддй ёей цүдүа ой өой ё/:1
 - дагалдагч суралцагчид /түүний дотор магистрант, докторант/:3 аааэй а.

- 3.10. Багийн ахлагч өөрийн сургалтын үйл ажиллагааны 30% хүртэлх хувийн семинар дадлагын ноогдлыг багийн тэтгэлэг авч байгаа дагалдагч докторантаар заалгаж болно.
- 3.11. Профессорын багийн бүрэлдэхүүнд бусад үндсэн нэгжийн профессор, багш, судлаачид, суралцагчид гишүүнээр ажиллаж болно. МУИС нь салбар дундын судлаачдын багийн үйл ажиллагааг түлхүү дэмжиж ажиллана.

Дөрөв. Профессорын багийн удирдлага

Багийн ахлагчид тавигдах шаардлага:

- 4.1. Багийн ахлагч нь МУИС-ийн профессор багш ажиллуулах журамд заагдсан профессорын албан тушаалд ажиллахад тавигдах тусгай шаардлага, үзүүлэлтийг бүрэн биелүүлсэн байх;
- 4.2. Судалгааны үр дүн нь үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн байх /бүтээл нь мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн, ишлэл хийгдсэн/;
- 4.3. Олон улсын түвшний судалгаа, хамтын ажиллагааны туршлага, түнштэй байх;
- 4.4. Өөрийн судалгааны чиглэлээр хоёроос доошгүй гадаад хэлийг мэргэжлийн түвшинд хэрэглэдэг байх;
- 4.5. Магистр, докторын түвшинд мэргэжлийн хичээл заадаг байх;
- 4.6. $\zeta \delta \epsilon \iota \acute{\alpha} \acute{\alpha} \epsilon \acute{\alpha} \delta \delta$, багаар ажиллах $\acute{\alpha} \acute{\iota} \acute{\epsilon} \acute{\iota} \acute{\iota} \acute{\eta} \acute{\omicron} \acute{\delta} \acute{\alpha} \acute{\alpha} \acute{\iota} \acute{\varsigma} \acute{\alpha} \acute{\alpha} \delta \acute{\alpha} \acute{\alpha} \acute{\varsigma} \acute{\zeta} \acute{\epsilon} \acute{\iota} \acute{\omicron} \acute{\iota} \acute{\alpha} \acute{\omicron} \acute{\delta}$ чадвар туршлагатай байх;
- 4.7. Судалгааны төсөл хэрэгжүүлдэг, магистрант докторантыг судалгааны ажлаасаа санхүүжүүлдэг бол давуу тал болно.
- 4.8. Бүрэлдэхүүн сургууль нь өөрийн онцлогт тохирсон нэмэлт шаардлагатай байж болно.

Багийн ахлагчийн үүрэг:

- 4.9. Судалгааны гэрээт болон захиалгат төсөл, сэдэвт ажил удирдаж, судалгааны ажлын санхүүжилт бүрдүүлэх;
- 4.10. Багийн эрдэм шинжилгээний төсвийн хуваарилалт, зарцуулалт, үр ашигт хариуцлага хүлээх;
- 4.11. Ааæéí ñóàèãàì û àæûî í òðàòàãè ø° è° âë° èðèéáâî êî âñðóóèàð;
- 4.12. Судалгааны ажилд удирдагч, чиглүүлэгч байх;
- 4.13. Өөрийн багийн сургалт, судалгааны ажлын чанар, үр дүнгийн өмнө бүрэн хариуцлага хүлээх;
- 4.14. Эрдэм шинжилгээний бүтээл тогтмол хэвлүүлэх;
- 4.15. Судалгааны холбогдох мэдээллээр судалгааны нэгжийн эрдэм шинжилгээний асуудал хариуцсан ажилтанг хангаж ажиллах;
- 4.16. Олон нийтийн сонгуульт ажил гүйцэтгэх;
- 4.17. Багийн гишүүд, суралцагчдад амьдралын туршлагаа хуваалцаж тэдний хүсэл тэмүүллийг дэмжих, зөвлөх;
- 4.18. Багш болон судлаачийн ёс зүйг чандлан мөрдөж ёс зүй, сахилга батын хувьд үлгэр жишээ байх;
- 4.19. Багт ажиллаж байгаа судлаачид, багш, суралцагчдын ёс суртахууныг эвдэх аливаа нөхцлийг гаргуулахгүй байх.

Багийн ахлагчийн эрх:

- 4.20. Багийн бүрэлдэхүүнд даахгүйгээр аах, судлаачдыг нэр дэвшүүлэх;
- 4.21. Судалгааны ажил эхлүүлэх суурь зардлаар хангагдах;
- 4.22. Үндсэн нэгжээс төсөвт тусгагдсан хэмжээнд эрдэм шинжилгээний тодорхой санхүүжилт авах;
- 4.23. Судалгааны ажил гүйцэтгэх гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд судалгааны ажлын санхүүжилтээс багийн магистрант, докторантыг цалинжуулах;
- 4.24. Багийн судалгааны ажлын төсвийн хуваарилалт хийх, зарцуулалтанд хяналт тавих;
- 4.25. Судалгааны ажил гүйцэтгэх өрөө, тасалгаагаар хангагдах;
- 4.26. Багийн гишүүдтэй судалгааны хариуцлага, үр дүнгийн гэрээ хийх;
- 4.27. Багийн гишүүдийн урамшууллын цалинг хуваарилах;
- 4.28. Багийн гишүүдэд сахилгын шийтгэл ноогдуулах санал гаргах.

Тав. Цалингийн сүлжээ, санхүүгийн эрхийн хязгаар

- 5.1. Профессорын багийн ахлагч болон гишүүдийн цалинг профессор, багшийн албан тушаалын шатлалтай нь уялдуулан МУИС-д мөрдөж буй цалингийн сүлжээгээр тогтооно.
- 5.2. Профессорын багийг шинээр байгуулахад зориулж нэг удаа судалгааны суурь зардлаар санхүүжүүлэх ба энэ нь байгаль, нийгмийн ухааны чиглэлээр ялгаатай байна. Багийн суурь зардал нь МУИС-ийн төвлөрсөн сангийн зардлын төсөвт тусгагдах ба цалинд зарцуулагдахгүй.
- 5.3. Багийн дагалдагч суралцагчдад МУИС-ийн төвлөрсөн сангийн зардлын төсөвт тусгагдсан хэмжээнд тэтгэлэг олгоно.
- 5.4. Бүрэлдэхүүн сургууль нь жил бүр профессорын багийн үйл ажиллагаанд зориулж тодорхой зардлыг эрдэм шинжилгээний зардлын төсөвт тусгана.
- 5.5. МУИС-ийн эрдэм шинжилгээний төвлөрсөн дансаар дамжин санхүүжигдсэн гэрээт болон захиалгат төсөл, сэдэвт ажлын зарцуулалтыг багийн ахлагч нь МУИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан албаар хянуулан гэрээний дагуу захиран зарцуулна. Бүрэлдэхүүн сургууль болон МУИС-аас санхүүжүүлэгдсэн эсвэл бүрэлдэхүүн сургуулийн дансаар дамжин санхүүжигдсэн гэрээт болон захиалгат төсөл, сэдэвт ажлын зарцуулалтыг багийн ахлагч бүрэлдэхүүн сургуулийн захиралтай хийсэн гэрээний дагуу хянуулан захиран зарцуулна.
- 5.6. Судалгааны ажлын нийт мөнгөн дүнгээс МУИС болон бүрэлдэхүүн сургуульд оруулах орлогыг “МУИС-ийн судалгааны үйл ажиллагааг дэмжих хуримтлал бүрдүүлэхэд баримтлах журам”-ын дагуу шийдвэрлэнэ.